


Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтэс 2018 оны 10 дугаар сарын хэргийн хөдөлгөөний мэдээг нэгтгэн, улсын хэмжээн дэх эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хэргийн хөдөлгөөний судалгааг танилцуулж байна.

1. Хүлээн авсан хэрэг, нэхэмжлэл:

2018.10.01-2018.10.31 -ний өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх анхан шатны шүүхүүд нийт 6942 хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас эрүүгийн 1315 хэрэг, иргэний 5407 нэхэмжлэл, захиргааны 220 нэхэмжлэл хүлээн авсан байна.

График.1



Дүүргийн анхан шатны шүүхүүдийн 2018 оны 10 дугаар сарын нэгдсэн тайлан мэдээнээс үзвэл Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 728 нэхэмжлэл, Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 177 хэрэг, нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх 147 нэхэмжлэл хүлээн авсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна.

Харин Багахангай дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 4 нэхэмжлэл, Багахангай дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2 хэрэг хүлээн авсан нь бусад дүүргүүдтэй харьцуулахад бага үзүүлэлттэй байна.

Орон нутаг дахь анхан шатны шүүхүүдийн хувьд Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх 184 нэхэмжлэл, Төв болон Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх тус тус 64 хэрэг, Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх 8 нэхэмжлэл хүлээн авсан байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Иргэний хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт 5407 нэхэмжлэлийн 3181 буюу 58,8%-ийг дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд хүлээн авсан байна.

Захиргааны хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт 220 нэхэмжлэлийн 147 буюу 66,8%-ийг нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хүлээн авсан байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт 1315 хэргийн 702 хэрэг буюу 53,4%-ийг дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд хүлээн авсан байна.

2. Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо:

Улсын хэмжээнд нийт 4837 хэрэг хянан шийдвэрлэснээс эрүүгийн 1088, иргэний 3607, захиргааны 142 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

10 дугаар сарын нэгдсэн тайлан мэдээгээр Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх нийт 384 хэрэг, Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 146 хэрэг хянан шийдвэрлэсэн байгаа нь улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ




График.3

3. Шүүх хуралдаан хойшилсон байдал:

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд 1332 шүүх хурал товлон зарласнаас 307 буюу 23%, иргэний хэргийн анхан шатны шүүхүүд 4921 шүүх хурал товлон зарласнаас 1832 буюу 37,2%, захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд 612 шүүх хуралдаан товлон зарласнаас 476 буюу 77,8% шүүх хуралдаан хойшилсон байна. Мэдээний хугацаанд 2615 шүүх хурал буюу анхан шатны шүүхүүдийн нийт зарласан 6865 хурлын 38,1% нь хойшилсон байна. Шүүх хуралдаан хойшилж байгаа судалгаанаас үзэхэд Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд 357, Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 44, нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх 410 хэргийн шүүх хуралдаан хойшилсон өндөр үзүүлэлттэй байна.

Шүүх хуралдаан хойшилсон байдал





График.4

4. Хугацаа хэтрэлт:

Улсын хэмжээнд нийт 7413 хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаагаас 897 хэрэг буюу 12,1%-ийг хугацаа хэтэрсэн хэрэг эзэлж байна. Хугацаа хэтэрсэн нийт хэрэгт эрүүгийн 1, иргэний 732, захиргааны 164 хэрэг байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 729 хэргийн 3 буюу 0,1%, иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 6101 хэргийн 732 хэрэг буюу 12%, захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 583 хэргийн 164 хэрэг буюу 28,1% нь тус тус хугацаа хэтрэлттэй байна.

Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх 157, нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх 144 хэргийн хугацаа хэтрэлттэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.



**10 ДУГААР САРЫН НЭГДСЭН ДҮН:**График.6
/Эрүү/

Д/д	Шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтэрсэн
1	Нийслэл дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	702	581	450	-
2	Орон нутаг дахь эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд	613	507	279	1
3	Нийт	1315	1088	729	1

График.7
/Иргэн/

Д/д	Шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтэрсэн
1	Нийслэл дэх Иргэний хэргийн анхан шатны шүүхүүд	3181	1871	3928	654
2	Орон нутаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхүүд	2226	1736	2173	78
3	Нийт	5407	3607	6101	732

График.8
/Захиргаа/

Д/д	Шүүх	Хүлээн авсан	Хянан шийдвэрлэсэн	ХХША-д	Хугацаа хэтэрсэн
1	Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх	147	75	472	144
2	Орон нутаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхүүд	73	67	111	20
3	Нийт	220	142	583	164